

**1948** НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал баталсан

**1951** НҮБ-ын Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенц батлагдав

**1961** Петр Бенинсон «The Observer» сонинд «Мартагдсан хоригдлууд» өгүүллэгээ хэвлүүлэн уриалга гаргаснаар Эмнести Интернэшнл үүсгэн байгуулагдав.

**1963** Лондон хотноо Эмнести Интернэшнлийн төв болон Олон Улсын Нарийн Бичгийн Дарга Нарын газар байрлав.

**1964** Эмнести Интернэшнл НҮБ-д зөвлөх эрхтэй болов

**1965** Арьс өнгөөр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенц батлагдав

**1966** Иргэний болон улс төрийн эрх, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухайн олон улсын пактууд батлагдав  
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт Протокол батлагдсанаар Хүний Эрхийн Комисс хувь хүний гомдлыг хүлээн авах, хэлэлцэх боломжтой болов.

**1967** Дүрвэгсдийн эрх зүйн байдлын талаархи конвенцийн Нэмэлт Протокол батлагдав. Энэ нь цаашид дэлхий даяархи дүрвэгсдийг хамгаалах томхон алхам болов

**1972** Эмнести Интернэшнл эрүүдэн шүүхийн эсрэг анхны кампанит ажлаа өрнүүлэв

**1973** Эмнести Интернэшнлийн кампанит ажлын үр дүнд НҮБ-ын Ерөнхий Ассамблей эрүүдэн шүүхийг гэмт хэрэг гэж үзсэн 3059 тоот тогтоолоо гаргав

**1975** Эмнести Интернэшнлийн кампанит ажил амжилтанд хүрч НҮБ-ын Ерөнхий Ассамблей Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай Тунхаглалыг баталлаа.

**1977** Эрх чөлөө, шударга ёсыг хамгаалж, даян

дэлхийд энх тайван байдал тогтооход оруулсан хувь нэмрээрээ Эмнести Интернэшнл Нобелийн Энх Тайвны шагнал хүртэв

Эмнести Интернэшнл чуулганаараа Цаазаар авах ялын талаархи Стокольмийн Тунхаглал батлан гаргаж «Бүх засгийн газруудыг цаазаар авах ялыг яаралтай халах»-ыг уриалав.

**1978** Хүний эрхийн салбарт оруулсан хувь нэмрийг нь үнэлж НҮБ «Хүний эрхийн шагнал»-аа Эмнести Интернэшнлд гардуулав.

**1979** Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц батлагдав

**1980** НҮБ-ын хүний эрхийг хамгаалах тогтолцоонд «Хүчээр сураггүй алга бологсдын асуудлаархи ажлын хэсэг» байгуулагдав. Цаазаар авах ялын эсрэг дэлхий даяарх кампанит ажлаа Эмнести Интернэшнл эхлүүлэв.

**1983** Олон улсын хүний эрхийн өдрөөр үзэл санааны бүх хоригдолд даян дэлхийн өршөөл үзүүлж, суллахыг уриалсан 1 сая гаруй хүний гарын үсэг цуглуулав.

**1984** Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенц батлагдав. Цаазаар авах ялтай этгээдийн эрхийг хамгаалах, тэдний эрхийн хэрэгжилтийг онцгойлон хянах баримт бичиг батлагдав

**1988** Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд батлагдав.

**1989** Хүүхдийн эрхийн тухай Конвенц батлагдав  
Цаазаар авах ялыг халахыг зорьсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 2 дугаар Нэмэлт Протокол батлагдсан бөгөөд энэ үеэс Эмнести Интернэшнл цаазаар авах ялын эсрэг 2 дахь кампанит ажлаа дэлхий даяар өрнүүлэв

**1990** Бүх цагаач ажилтан ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай Олон улсын Конвенц батлагдав  
Нийгмийн хэв журам сахиулах байгууллагын



ажилтнууд хүч ба галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд батлагдав.

1993

«Хүний эрх түгээмэл, салшгүй, бөгөөд жам ёсны» гэдгийг дахин баталгаажуулсан Венийн Тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрийг Хүний эрхийн дэлхийн чуулганаас батлав.

Эмнести Интернэшнлийн явуулсан шургуу кампанит ажлын үр дүнд Хүний эрхийн дээд комиссарын газар байгуулагдав.

1995

«Эмэгтэйчүүдийн эрх бол хүний эрх» гэдгийг баталгаажуулсан Үйл ажиллагааны хөтөлбөр болон Бээжингийн Тунхаглалыг Эмэгтэйчүүдийн асуудлаархи дэлхийн 4 дүгээр чуулган батлав.

1997

Эмнести Интернэшнл НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд хэлэлцэх асуудалдаа хүний эрхийн тухай оруулахыг сануулав.

1998

Эмнести Интернэшнлийн шургуу явуулсан кампанит ажлын үр дүнд Олон улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм батлагдав  
Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх, үүргийн тухай Тунхаглал буюу Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах Тунхаглал батлагдав

1999

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх үзлийг устгах тухай олон улсын конвенцийн Нэмэлт Протокол батлагдсанаар Эмэгтэйчүүдийг алагчилахын эсрэг Хороо хувь хүн, бүлэг этгээдийн гомдлыг хүлээн авах, хэлэлцэх боломжтой болов  
Эмнести Интернэшнл зэвсэгийг хянах даян дэлхийн кампанит ажлаа эхлүүлэв

2000

Зэвсэгт мөргөлдөөнд хүүхдүүдийг татан оролцуулахгүй байх асуудлаархи Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн Нэмэлт Протокол батлагдав  
Хүүхдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тухай Хүүхдийн эрхийн конвенцийн Нэмэлт Протокол батлагдав  
Эмнести Интернэшнл байгууллага, тэр дундаа эмэгтэйчүүдийн бүлгүүдээс явуулсан

томоохон кампанит ажлын үр дүнд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл зэвсэгт мөргөлдөөний үеэрх болон мөргөлдөөний дараах эмэгтэйчүүдийн асуудлын талаархи 1325 дугаар тоот тогтоолоо гаргав.

2002

Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт протокол батлагдав  
Гаг хотноо Олон Улсын Эрүүгийн Шүүх байгуулагдав

2004

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох даян дэлхийн кампанит ажлаа Эмнести Интернэшнл эхлүүлэв

2005

Олон улсын хүмүүнлэгийн хууль зөрчсөн томоохон зөрчил, Олон улсын хүний эрхийн томоохон зөрчлийн хохирогчдыг цагаатгах, нөхөн сэргээх тухай Үндсэн зарчим батлагдав

2006

Албан хүчээр сураггүй алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай Конвенц батлагдав  
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын Конвенцийн Нэмэлт Протокол батлагдав  
Хүний эрхийн Комиссын оронд НҮБ-ын хүний эрхийн зөвлөл байгуулагдав  
«Зэвсэгийг хянах» кампанит ажлын үр дүнд НҮБ-ын Ерөнхий ассамблей Олон улсын зэвсгийн худалдааны гэрээг батлахыг дэмжүүлэхээр санал хураалт явуулав.

2007

НҮБ-ын Үндэсний цөөнхийн эрхийн тухай Тунхаглалыг Ерөнхий Ассамблей батлав  
Дэлхий даяар цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлэхийг уриалсан тогтоолыг Ерөнхий Ассамблей батлав

2008

Хувь хүн болон бүлэг хүмүүсээс ирсэн гомдлыг Хороо хүлээн авах, хэлэлцэх боломж олгосон Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт Протоколыг Ерөнхий Ассамблей батлав. Португал улсын танилцуулсан уг нэмэлт Протоколыг 12 дугаар сарын 10-ны өдөр ХЭТТ-ын 60 жилийн ойн өдөр Ерөнхий Ассамблейн хурал дээр эцэслэн батлах юм.